



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

“Плэйтийм” олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан тоглолт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/421 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орчин үеийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг дэлхийн нийтэд сурталчлах зорилгоор “Плэйтийм” олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан тоглолтыг жанжин Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 16,672,000 /арван зургаан сая зургаан зуун далан хоёр мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.


4. Арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500132

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 05 сарын 02 өдрийн
A/02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
В.Батчимэг

Гишүүд:

Маркетинг сурталчилгаа хариуцсан
ахлах мэргэжилтэн С.Туул

Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан
мэргэжилтэн Б.Цолмонгэрэл

“Амьд хөгжмийн наадам” ТББ
/тохиролцсоноор/

Нарийн бичгийн дарга:

Эвент хариуцсан мэргэжилтэн
Б.Үржинханд

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 05 сарын 02 өдрийн
A/22 дугаар хоёрдугаар тушаалын хавсралт

“ПЛЭЙТАЙМ” ОЛОН УЛСЫН ХӨГЖМИЙН НААДМЫН УРЬДЧИЛСАН
ТОГЛОЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Талбайн тохижилтын зардал				
1	Асар түрээс 5*5	4	143,000	572,000
2	Арга хэмжээний тайзны лед дэлгэц түрээс	Багц	7,000,000	7,000,000
3	Хөгжим техник угсралт	Багц	3,500,000	3,500,000
4	Тог цахилгаан	Багц	600,000	600,000
Зохион байгуулалтын зардал				
5	Урлагийн тоглолт	Багц	5,000,000	5,000,000
Дүн				16,672,000

--- оОо ---